

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№20/524

ШУС, НУС

2019

**МОНГОЛЫН СОНИН ХЭВЛЭЛИЙН НИЙТЛЭЛИЙН**  
**ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Б.Болд-Эрдэнэ\*

\*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбар хариуцсан дэд захирал, доктор (Ph.D), дэд профессор

**Түлхүүр үг:** нийтлэлийн онцлог, мэдээлэл, мэдлэг, үнэлэмж

**Н**ийтлэл нь хувь хүний төдийгүй нийгмийн харилцааны нөлөө бүхий утга агуулгын орчин юм. Хүний ертөнцийн мөн чанар нь дотоод болон гадаад орчны тэнцвэржилт буюу ойлгомжтой, танил дүр төсөөллөөр аливааг үнэлж дүгнэхэд оршдог. Бодол санаа, сэтгэл зүй гэгч тухайн хүний сонирхол, эрх ашиг, үзлийг бусад хүмүүс, нийгэм цаашилбал ахуй орчин хэрхэн тэтгэн, хүлээн зөвшөөрч буй эсхүл үгүйсгэж буй байдлын үр дүн гэж болно. Өөрөөр хэлбэл хүний дотоод ертөнц ба бодит байдал хоорондын шууд харилцан хамаарлаас үүдэн түүний итгэл үнэмшил, мэдлэг, туршлага төлөвшиж байдаг. Тиймээс ч хүн өөрийнхөө “цонхоор” ертөнцийг хардаг гэсэн эрт үеийн үг үеэс үед уламжлагдан ирсэн хэрэг.

Харин нийгмийн талаас нэгэнт тогтон бүрэлдсэн соёл, үнэлэмж, итгэл үнэмшлээ хувь хүн бүрийн ухамсар, санаа бодол, сэтгэл зүйд хүлээн зөвшөөрүүлэх, нэгтгэх зайлшгүй “хүсэл зориг” байдаг. Нийгэм нь амьд тогтолцоо хэмээн үзвээс бүрдэл нэгж эд эсээ нэгэн цогц орчиндоо нэгтгэх зайлшгүй эрх мэдэл байхаас өөр гарцгүй. Энэхүү

шалтгаанаар ч хууль ёс, боловсрол, ёс суртахууны нөлөө, үнэ цэнийн ач буян оршиж байдаг.

Хүн ба нийгэм гэдэг бие даасан оршихуйн холбоо нь харилцаа юм. Харилцааг энгийнээр тодорхойлбол утга агуулга бүхий тэмдэгтийн түгээлт, солилцоо, түүний үр болох нөлөө гэсэн томъёоллоор ойлгож болно. Сэтгүүл зүй нь нийгмийн харилцааны нэг орчин болохын хувьд утга, тэмдэгтийн түгээлтээс гадна түүнийг дамжуулж, илгээж буй мэдээллийн технологи, хүмүүсийн эрэлт хэрэгцээгээр тодорхойлогдох учиртай.

Сонин хэвлэлийн хувьд үг хэл, үсэг шрифт, гэрэл зураг, дүрст тэмдэгт (схем, график), цаас хэвлэлийн тоног төхөөрөмж, программ хангамж интернет технологи, хотын соёл, хувь хүний нийгэмч эрэлт хэрэгцээ гээд олон хүчин зүйл, өргөн хүрээнд дүн шинжилгээ байж сая бүрэн тодорхойлогдох болно. Мэдээж сонины нийтлэлийн тухай яриа ч дээрх хүчин зүйлийн нөлөө, тайлбараар үргэлжлэх болно.

Нийтлэл нь хувь хүний бодит байдал, цаг үеэ үнэлэн дүгнэх болоод нийгмийн эрх мэдэл, нөлөөгөө тогтоох, хадгалах эрэлт шалтгааны огтлолцол, үр дүнгээр оршдог харилцааны нэгэн “эд, эс” юм. Энгийнээр хэлбэл хувь

хүний үзэл бодолтой байх, илэрхийлэх төрөлх эрх болон нийгмийн дэг журам, соёл, эрх ашгаа хадгалах зайлшгүй эрэлт зэрэг нь нийтлэлийн нөлөө, үнэ цэнэ юм. Хүн, хүний нийгмийн мөн чанар нь ухамсарт, зорилго бүхий харилцаагаар бодит зүйл болдог харин үр дүн нь соёл иргэншлийг бий болгон, төлөвшүүлдэг учиртай. Ийнхүү нийтлэлийн хүн нийгэмд үзүүлэх нөлөө, эрэлт шалтгааны үндэс суурь нь мэдээллээс (баримт) мэдлэг, мэдлэгээс үзэл санаа, үзэл санаанаас итгэл үнэмшил, итгэл үнэмшлээс үнэлэмж гэсэн ухамсар, оюун ухааны хөгжлийн зүй тогтолд байна. Тиймээс баримт нь нийтлэлийн бодит үнэн, нөлөө бүхий утга агуулгын цогц болох эсэхийн эх үндэс төдийгүй мэдлэг, итгэл үнэмшил нь юм. Нөгөө талаар тухайн нийгмийн эрх ашиг, итгэл, үнэлэмжийн илэрхийлэл, “өдөөлт” бүхий үйл явдал үзэгдлийн тухай байж хүний болоод олон нийтийн анхаарлыг татна. Өөрөөр хэлбэл баримт, мэдээ бол нийтлэлийн нийгэмд нөлөөлөх эрэлт шалтгааны “гинжин холбоос”-ын эхлэл нь төдийгүй төгсгөл нь болно.

Орчин үеийн хүний хувьд ч мэдээллийн технологийн хөгжлийн үр нөлөөгөөр өгөгдөл, баримтын их сан, даяар сүлжээнээс чухал хэрэгтэйг сонгох, нийгэм гадаад орчноо зөв голчтойгоор үнэлж ойлгох сорилт тулгарч байна. Үнэхээр өдгөө хүн гэгч

баримт мэдээллийн өргөн боломж, нөөцийн “далайд төөрч будилсан хөлөг онгоц”-ын адил хэрэгцээгүй, чухал бус агуулгаар дүүрэн орон зайд мэдлэг ухаан, итгэл үнэмшлээ гэж байна. Үүний нэгэн тод томруун жишээ нь ч нийгмийн сүлжээ тойрсон төөрөгдүүлэлт, худал мэдээллийн тухай өргөн хэлэлцүүлэг, шүүмжлэлийн дүр зураг билээ. Нийгмийн сүлжээний “баримт”-

ын сөрөг үр дагаврын хүрээ, хувь хүн хоорондын итгэлцлээс улс орны төрийн тэргүүний сонгууль (АНУ, Герман, Монгол) хүртэл хамарч үр нөлөө нь сэтгэл зүйн дарамтаас даяарчлалын үнэт зүйлийг ч (эдийн засгийн даяарчлал, худалдааны чөлөөт зарчим) эвдэн сүйтгэх түвшинд хүрлээ.

Тэгэхлээр баримт гэдэг нийтлэлийн агуулга үр нөлөө, үнэ цэнэ бүхнийг багтаасан нэгж бүрдэл нь төдийгүй тухайн хувь хүн цаашилбал нийгмийн оюун санаа

сэтгэл зүйг “харах цонх” нь юм. Тэгээд ч баримт мэдээллийн үнэ цэнэ нь мэдлэг ухаан болох утгын чанарт оршдог нь итгэл үнэмшил үнэт зүйлээр тунгаагдан үр нөлөөгөө үзүүлэх зүй тогтолд оршино. Бид баримтыг буй агуулгаар нь бус харин нийгмийн эрх ашиг ба хувь хүний дотоод ертөнцийн тэнцвэржилтэд холбогдох үнэ цэнээр нь эрэмбэлэх ёстой. Нөгөө талаар “сэтгүүлчийн ур чадвар нь баримтад тулгуурлан итгүүлэн үнэмшүүлэх буюу гол, чухал



**Баримт гэдэг нийтлэлийн агуулга үр нөлөө, үнэ цэнэ бүхнийг багтаасан нэгж бүрдэл нь төдийгүй тухайн хувь хүн цаашилбал нийгмийн оюун санаа сэтгэл зүйг “харах цонх” нь юм. Тэгээд ч баримт мэдээллийн үнэ цэнэ нь мэдлэг ухаан болох утгын чанарт оршдог нь итгэл үнэмшил үнэт зүйлээр тунгаагдан үр нөлөөгөө үзүүлэх зүй тогтолд оршино. Бид баримтыг буй агуулгаар нь бус харин нийгмийн эрх ашиг ба хувь хүний дотоод ертөнцийн тэнцвэржилтэд холбогдох үнэ цэнээр нь эрэмбэлэх ёстой**



баримтуудыг сонгох, нэгтгэх, задлан шинжлэх, улмаар тэдгээрийн харилцан холбоо, нөлөөллийг тогтоосны үндсэн дээр өөрийн санаа бодол, үзэл баримтлалыг дэвшүүлэн тавих чадвар”<sup>1</sup> юм гэж тодорхойлсон нь баримтын үнэ цэнэ, эрэмбэ бүхний үндэс болохыг нотолж буй хэрэг.

Монголын өнөөгийн сонин хэвлэлийн нийтлэлийн агуулгыг томъёолбол баримт мэдээ нь улстөрч, эрх баригчдын шударга ёс, тэгш эрхийн тухай уриа, төрөөр тэтгүүлэх, төрд бүхнийг даатгах халамжийн амлалт, эрх мэдэл засаглалыг авах зорилгот худал төөрөгдүүлэлтийн үг, тайлбар, тоо жишээгээр дүүрч байна. Энэ бол Монголын нийт сонин хэвлэлийн нийтлэлийн агуулгын 55-70 хувь нь улс төрийн үйл явдал, баримтын хүрээнд “эргэлдэж” буйн дээр, дүгнэлт тайлбарын 90-95 хувь нь төрийн оролцоо, үүргийг онцолж, шийдэл гарцыг халамж, байгалийн баялгийн ард түмний өмчлөл, шударга ёсын тухай “онол”-оор тодорхойлж буй судалгааны дүн нотолж байна. Цаашилбал 2018, 2019 оны сонин хэвлэлийн нийтлэлийн гол сэдэв төрийн албыг 60 тэрбумаар наймаал-сан МАН-ын удирдлагын гэх хэрэг, Эрдэнэтийн 49 хувийг улстөр санхүүгийн бүлэглэл “төрийн мөнгө”-өөр худалдаж авсан тухай дуулиан, УИХ-ын 40 гаруй гишүүн ЖДҮ-ийн тэрбум төгрөгөөр хэмжигдэх зээлийг 3 хувийн хүүтэй 20 хүртэл жилийн хугацаатай хувийн компанидаа авсан, мөнгө хүүлэх хэрэгсэл болгосон тухай шуугиан, Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт тойрсон хэт улстөржсөн маргаан мэтгэлцээн гээд үргэлжилж байна. Мөн Оюутолгойн гадаадын хөрөнгө оруулалт, Таван толгойн хувьцаа эзэмшилт, Цагаан суварга, Ноён уул, Тост, тосон бумбын орд тойрсон

ард түмний өмчлөл, баялгийн хувиарлалт, гадаадын хөрөнгө оруулалтын талаарх хэт туйлшралын мэдээ баримтад үндэслэсэн нийтлэл олон нийтийн санаа бодолд нөлөөлж буйг онцлон тэмдэглэх ёстой.

Энэхүү нийтлэлийн агуулгын түрэлтийн үр дүнд өнөөгийн монгол хүний оюун ухамсарт бэлэнчлэх, бусдаар тэтгүүлэх, хялбар амар аргаар баяжих, зээл өглөгт шүтэх үзэл санаа төлөвшиж, төрийн халамж, баялгийг нийтээр хүртэх, элитийг үгүйсгэх, хөрөнгө бүхий бүлгийг үзэн ядах итгэл үнэмшил бүрэлдэж улмаар амин хувиа хичээх, өөрийгөө дээдлэх үнэлэмж ноёрхох боллоо. Тиймээс ч Монголын нийгмийн хямрал, зөрчил нь эрүүл оюун ухаант, хэмнэгч, өөрийнхөө амьдралын төлөө хариуцлага хүлээгч нийгмийн гишүүнээ “хүмүүжүүлж” чадаагүйд оршиж байна. Мэдээж энэхүү хямралд хүргэсэн нэг гол хүчин зүйл нь сонин хэвлэлийн нийтлэлийн агуулга, дүгнэлт тайлбар билээ.

Түүнчлэн коммунист сэтгүүл зүйн ухуулах, үзэл суртлын хэрэгсэл болох, нийгмийн амьдралыг зааварчлах зэрэг уламжлал, хандлага ч амь бөхтэй оршсоор байна. Эдийн засгийн нийтлэл л гэхэд бизнес санхүүгийн орчинд бодит, мэргэжлийн түвшний дүн шинжилгээ хийх бус харин улс төржсөн, популист амлалт, ард түмний өмчлөлийн тухай хийсвэр мэдэгдэл, зах зээлийн өрсөлдөөнт орчин, дэг журамд үл нийцэх тайлбар, үгүйсгэлээр агуулгаа дүүргэж байна. Өөрөөр хэлбэл эдийн засгийн нийтлэл, нэвтрүүлэг нь улс төрөөс ангид, мэргэжлийн байж сая үнэ цэнэтэй болдог.

Ер нь 1980 оны сүүл үеийн өөрчлөн байгуулалтын үеэс эхэлсэн эдийн засгийн тогтолцооны тухай шүүмжлэл, үгүйсгэл өдгөө тусгагдахуун

(өмнө нь улсын өмч байсан одоо хувийн өмч) нэр томъёо (социализмыг томоохон орд, үндэсний хөрөнгөтнөөр сольсон) үзэл баримтлал (нэг намын дарангуйллыг улс төр санхүүгийн бүлэглэлээр төсөөлдөг болсон) зэрэг хэлбэрийн өөрчлөлт төдийгөөр өнөөгийн нийтлэлд үргэлжилж байна. Тиймээс чөлөөт хэвлэл хэмээх нэр томъёо бол улс төр, нийгмийн нийтлэлийнх харин эдийн засгийн асуудалд мэргэжлийн шалгуур, төвшин гол үнэт чанар нь байх ёстой. Гэтэл манай эдийн засгийн сэтгүүл зүйд улс төрчдийн амлалт, уриа, “мэдэмхийрэл” хэрээс хэтэрч чөлөөт өрсөлдөөн, гадаадын хөрөнгө оруулалт, хөрөнгөжсөн хэсгийн манлайлал, технологийн хөгжлийн оройлол зэрэг тайлбар, дүгнэлтийг үгүйсгэх боллоо.

Нийтлэлийн агуулгыг тодорхойлох өөр нэгэн чухал хүчин зүйл нь зохиогч, нийтлэлчийн мэдлэг, байр суурь болоод ур чадвар юм. Нийтлэл нь ч хувь хүний үзэл бодлоо илэрхийлэхүйн дээд хэлбэр учир зохиогчоос сэдэв сонголт, ончтой шинэлэг санаа, нийгэм, цаг үеийн эрх ашгийн эерэг байр суурь, зохист зохиомж, илэрхийлэл, үгийн сангийн баялаг найруулга бүхий, товч бичих ур чадварыг “шалгадаг”.

Гэхдээ хамгийн чухал нь нийтлэлч нийгмийн үйл явдал, үзэгдлийг нийгмийн “цонх, шүүлтүүр”-ээр харж нягтлах ёстой. Үүнд мэдээж хувь хүний итгэж үнэмшсэн мэдлэг ухаан, үзэж өнгөрүүлсэн амьдралын туршлагын хувь хэмжээ байх ч нийгмийн эрх ашиг, “өнцөг”-өөс бүхнийг тунгаах хэрэгтэй. Харин манай нийтлэлчдийн байр суурийг хувь хүний үзэл хандлага бүр цаашилбал хэн нэг “захиалагчийнхаа” эрх ашигт үйлчилж байна. Энэ нь эрх баригчид эсвэл улстөрчдийн

үзэл суртлыг “үг, жишээ”-гээр “өнгө аяс” оруулан давтах, туйлшрах нэг талыг дөвийлгөх, хэт өрнөдийн, бодит бус онол эш үзлийг хэтийтгэн “шүтэх” эсхүл ямар нэгэн цаг үеийн дуулиант баримт, үйл явдалд тулгуурлан бүхнийг дүгнэх зэрэг агуулгын өнөөгийн байдлын гол шалтгаан юм. Социалист нийгмийн үед “улс орны амьдралыг өөдрөг, хувь хүний-хийг гутранги үнэлэх” хандлага байсан бол өдгөө “улс орны үйл явдал, асуудлыг үгүйсгэх, хувь хүний үүрэг оролцоог хэт магтах, дөвийлгөх” өнцөг нийтлэлчдийн дунд ноёрхож байна.

Нийтлэлийн зорилго ч олон нийтийн санаа бодолд хэт сохроор дулдуйдах, улс төрийн ПиАр, популизмийн үзэл суртлын “зэвсэг” болгох, цаг үеийн дуулиан шуугианыг дэвэргэх зэрэг “эрүүл бус” нөлөөллийн төлөө хошуурч байна. Тиймээс ч гутранги үгүйсгэл эсвэл хэтийдсэн магтаал гэсэн хоёр агуулга нийтлэлийн орон зайг эрхшээх болов. Сонгуулийн өмнөх жилийн сурталчилгаа, Засгийн газрын огцролт, хавар намрын цаг үеийн асуудал (өвөлжилт, зуд, үер, утаа, тариалалт, мал төллөлт зэрэг) улс төрийн дуулиан шуугиан (УИХ-ийн гишүүний гэмт хэрэг, ЖДҮ зээлээс их хэмжээний мөнгө авсан зэрэг) байгалийн баялаг эзэмшил, гадаадын хөрөнгө оруулалтын хүрээнд буй сэргэлдөөн гээд нийтлэл зүйн өрөөсгөл, явцуу эрх ашгийн төлөөх төөрөгдүүлэлт, олон нийтийн анхаарлыг татах зорилгот мэдээллийн довтолгооны жишээ жагсаалтыг олныг дурдаж болно. Гэтэл нийтлэл бол нийгмийн эрх ашгийг эрүүл бодит, оюун дүгнэлтээр шүүн тунгааж, тулгарч буй сорилт, бэрхшээлийг даван туулах боломжийг шинэлэгээр нээн гаргаж бүх нийтийн санаа бодол, байр суурьт нөлөөлөх, хэлэлцүүлэг, зөвшил-

цөлд хүргэх зорилго бүхий задлан шинжилгээний сэтгүүл зүй билээ.

Эрт цагаас хүн аливаа бодит байдал, үзэгдлийг үнэлж дүгнэх, илэрхийлж ойлгох дүр төсөөлөл нь тоочин өгүүлэхүй, шинжлэн судлах, уран сайхнаар дүрслэн илэрхийлэх гэсэн арга байдлаар хөгжиж иржээ. Мэдээж энэ нь өнөөгийн хүний мэдээлэл, утгыг бүтээх бүхий л жишээ, орчинд түгээмэл байсаар байна.

Хүний байгаль ертөнц, нийгэм, гадаад орчин, хүний амьдралыг төсөөлөх төрөлх арга нь тоочин өгүүлэхүй бөгөөд эрт үеэс нийгмийн харилцааны үндсэн “зэвсэг” байсан. Энэ үеийг аман харилцааны эрин хэмээн үзнэ. Аман харилцаа нь хүн төрөлхтний сэтгэлгээний түүхэнд сүсэг бишрэл, овгийн байгуулал төдийгүй ёс суртахууны анхдагч мөрдлөг болох хорио цээр, хүнчлэлийн суурь зарчмыг дагуулсан эрин юм. Ер нь хүнийг “хүн” болгосон гол хүч нь төсөөлөл бөгөөд түүнээс улбаалан итгэл үнэмшил, сүсэг бишрэл, төлөөлүүлэл хэмээн оюун ухаан, ухамсрын бүтээгдэхүүн боловсорсон хэрэг. Үг яриа нь хамгийн төгс тэмдэгтийн тогтолцоо хэмээн хүлээн зөвшөөрдөгийн уг мөн чанар ч эрт үеэс төлөөлүүллийн “хэрэгсэл” байж хөгжин ирсэнд оршино. Нөгөө талаас хэл яриа нь “ухамсарт бус” чанартай буюу утга агуулгын учир шалтгааны үндэслэл үгүй, нийгмийн зөвшилцөл, шууд даган дууриаллын “хүч”-ээр төлөвшсөн тэмдэгтийн орчин болно. Түүнчлэн үг хэлний утга илэрхийллийн боломж нөөц хязгаар-гүй байдаг нь тэмдэгтээс тэмдэгт үүдэн бүтэх зарчимд оршино. Гэрэл хэмээх үг гэхэд анхдагч утгаасаа өөр олон “санаа, билэгдэл, төлөөлүүлэл”-ийг илэрхийлэх болж амьдралын гэрэл, сэтгэлийн гэрэл бүр гэрлийн хурд хэмээх харьцангуй онолын нэр томъёо

болон “хувьссан” байх жишээтэй. Тэгэхээр тоочин өгүүлэхүй нь энгийн нэг төсөөлөл, илэрхийлэл бус харин утга билэгдлийн төгс тогтолцоо цаашилбал соёл, сэтгэлгээний орчноор “тайлагдах” санаа, дохио болно. Тиймээс нийтлэлийн өгүүлэмж нь тухайн цаг үеийнхээ тэргүүлэгч үзэл санаа, дүр төсөөллийнх байж сая ойлгогдох төдийгүй нөлөөлөх болно. Нөгөө талаар нийтлэлч нийгэм соёлынхоо билэгдэл, үнэлэмжийг тодотгох, үгийн тод, бүрэн утгат хэл найруулгаар бичих ёстойг онцлон тэмдэглэж байна.

**Х**үний дотоод ертөнц, төсөөллийн хоёрдах “өнцөг” болох уран дүрслэл, хүнчлэл, ёгтлол, харьцуулал зэрэг сэтгэлгээний илэрхийлэл нь аман харилцааны үеэс уламжлан бичгийн соёлд төгөлдөржин ирсэн нийтлэлийн арга хэлбэр юм. Шог өгүүлэл, уран нийтлэл, зураглал зэрэг бие даасан зүйлээс гадна ёгтлол, хүнчлэл, амьдчилал нь нийтлэлийн агуулгад түгээмэл байдаг. Үүнийг ч профессор М.Зулькафиль «... Бодит баримт, үзэгдлийг нэгтгэн дүгнэж, уран сайхны шог хошин дүр бүтээх зорилгыг агуулдаг; оршиж буй дутагдал, доголдлыг илчлэн шүүмжилж, баримтаа уран сайхны аргаар боловсруулдаг; бүтээсэн уран сайхны шог хошин дүр нь ямагт бодит хүн байдаг; баримтыг нэгтгэн дүгнэхдээ тэдгээрийн дотоод мөн чанар, хандлагыг нээн илрүүлж, дутагдал доголдлын шалтгаан, үр дагаврыг харуулдаг; тусгаж буй сэдвийн дотоод мөн чанарт нэвтэрч, илчлэх зорилгоор хэтрүүлэл, зүйрлэл, адилтгал, элэглэл, егөөдөл, ингүүн үг зэрэг уран сайхан, шог хошин найруулгын элементүүд, хэрэглүүрүүдийг өргөн ашигладаг; зохиогч санаа бодлоо оновчтой илэрхийлэх, буруушааж байгаа зүйлдээ хэрхэн хандаж байгаагаа

илтгэх зорилгоор инээдэмт зүйл, элементүүдийг ашигладаг»<sup>2</sup> гэж тодотгосон нь бий.

Бичиг үсэг хэрэглэх болсноор юм, үзэгдлийг илэрхийлэх, төсөөлөхүйд утгад шүтэн төлөөлүүлэх зайлшгүй байдал бий болсон. Энэ нь өгүүлж буй юм үзэгдлээ нэг бүрчлэн тоочих, тодорхойлох боломж хязгаарлагдмал болж, уг тусгагдахуунаасаа хэт “алсарсан”, бодит бус орчин, харилцааны нөхцлөөс үүдэн гарсан илэрхийллийг ашиглах болсонтой холбоотой. Хүн хүртэн мэдэрч буй ухамсар, сэтгэлээ бичгээр илэрхийлэхүйд шууд бүхнийг тоочих боломжгүй төдийгүй бүрэн төгс бус тул гол онцлог утгыг хөөн дүрслэх, адилтгах, харьцуулах болдог. Тиймээс хүнчлэл, амьдчиллаар утгыг тодотгох хялбар төдийгүй үр нөлөөтэйн дээр мэдээлэгчийн мэдрэмж, төсөөлөл бүрэн илэрхийлэгддэг. Ийнхүү үгийн утга далд, ёгт, уран сайхны болон өргөжин тэлж, бичгийн хэмээх цоо шинэ соёл, иргэншил, цаашилбал нийгмийн соёл, үнэлэмж бий болсон хэрэг. Өөрөөр хэлбэл цаг хугацаа, орон зайнаас үл хамаарах, бодит юм үзэгдлээс ангид, зөвхөн хүний сэтгэлгээ, итгэл үнэмшлийн орон зайд нээгдэх “утга агуулгын нийгэм” орших болов. Ийнхүү эзэнт гүрэн, цаасан мөнгө, хууль зарлиг, яруу найраг, шашин шүтлэг зэрэг хүн төрөлхтний соёл иргэншлийн “багана, суурь” хөгжин ноёрхсон хэрэг.

Хүний сэтгэлгээний түүх ч сүсэг бишрэлээс шашин шүтлэг, шашин шүтлэгээс шинжлэх ухаан гэсэн хувьсал өөрчлөлтөөр хэмжигддэг нь үг ярианаас бичиг үсэг, бичиг үсгээс томъёо загварчлалаар харилцааны “тэмдэгт”-ээ шинэчилж ирсэнтэй холбоотой.

Монголын өнөөгийн нийтлэлд ёгтлол, хошигнол, хэтрүүлэл хүнчлэл нь бичлэгийн ур илэрхийллийнх нь тэргүүлэх арга болж байгаа нь ч санаандгүй хэрэг биш ээ. Монголчуудын ертөнцийг үзэх үзлийн онцлог болох субъектив, хийсвэр, бодит бус, далдын “чанарт”-т итгэдэг дүр сэтгэхүй нь ч хүнчлэл, амьдчилал, билэгдлийн утга төсөөллөөр аливааг үнэлж ойлгох зан сэтгэлгээ бүхий үндэстэн болгон төлөвшүүлжээ. Энэ нь нүүдлийн мал аж ахуйн байгаль цаг агаараас шууд хараат, хадгалж хурааж үл болох өмч (мал сүрэг), ур чадвар, хөдөлмөрийг үнэлэхэд түвэгтэй ажил үүрэг бүхий амьдралын хэв маягаар төлөвшин тогтсон соёл, түүхтэй нь холбоотой. Тиймээс өмч хөрөнгө хураах, хэмнэх, хувь хүний хүчин чармайлт, бие даасан байдал, хууль журмыг ягштал баримтлах ухамсар зэрэг чанар сул болно. Харин байгаль дэлхий, төр засаг, хүчтэй ухаантай удирдагчийг шүтэн дээдлэх, юмс үзэгдлийн буй байдал бус харин мөн чанар, харилцан хамаарал, үр дагаврыг илүү эрхэмлэх болсон. Монголын нийтлэл төдийгүй сэтгүүл зүйд “баримт”-ын бус

«

**Монголын өнөөгийн нийт-лэлд ёгтлол, хошигнол, хэтрүүлэл хүнчлэл нь бичлэгийн ур илэрхийллийнх нь тэргүүлэх арга болж байгаа нь ч санаандгүй хэрэг биш ээ. Монголчуудын ертөнцийг үзэх үзлийн онцлог болох субъектив, хийсвэр, бодит бус, далдын “чанарт”-т итгэдэг дүр сэтгэхүй нь ч хүнчлэл, амьдчилал, билэгдлийн утга төсөөллөөр аливааг үнэлж ойлгох зан сэтгэлгээ бүхий үндэстэн болгон төлөвшүүлжээ**

»

“уран сайхан”-ы орон зай илүү нөлөө, байр суурь хүчтэй байдаг нь ч зан сэтгэлгээнийх нь эрэлт тааллаас эх шалтгаантай болой. Гэхдээ монгол нийтлэлийг “уран зохиол, утга уянгын” үг хэллэг, бичлэгтэй гэвэл эндүүрэл болно. Мэдээж баримт, тоо, жишээ, бодит түүх, үйл явдал үзэгдлийн шинжилгээ бий. Асуудлын гол нь, “уран сайхны” гэдэг нь дэвшүүлж буй санаа, тогтож буй дүгнэлт, нөлөөлж буй утга, тогтоож буй үнэлэмж зэргээ хэтрүүлэх, ёгтлол, хүнчлэл амьдчиллын төсөөлөл, төлөөллийн арга хэлбэрээр илэрхийлж буйд байгаа юм.

Хүний сэтгэлгээний гурав дахь илэрхийлэл, арга хэлбэр нь задлан шинжилгээ юм. Аливаа юмс үзэгдлийн мөн чанар, бодит үр дүн, учир шалтгааны зайлшгүй шүтэлцээ зэргийг нээн тайлбарлах, нотлох нь задлан шинжилгээний зорилго билээ. Задлан шинжлэх, судлан дүгнэх сэтгэлгээний хөгжлийн бодит үр дүн нь шинжлэх ухаан юм. Хүн төрөлхтний оюун санааны түүхийн сүүлийн 500 жилд л шинжлэх ухааны хөгжил багтдаг хэмээн үзвэл өдгөө технологийн нөлөө маш эрчтэйгээр өргөн хүрээнд түгэн, асар богино хугацаанд хүний нийгмийн эрс өөрчилснийг ойлгож болно. Хиймэл оюун ухаан, цөмийн физик, хар нүхний онол, интернет технологи гээд шинжлэн судлах, задлан шинжлэхүйн сэтгэлгээний “үр жимс” нээлт олон. “Сүсэг бишрэл-шашин-шинжлэх ухаан” хэмээх сэтгэлгээний хөгжлийн “газрын зураг” нийтлэл зүйн хөгжлийг ч тодорхойлох учиртай.

Нийгмийн хөгжилд эдийн засаг, эдийн засгийн өсөлтөд технологийн нөлөө бодит хүч болсон аж үйлдвэржилтийн эрин үеэс шинжлэх ухааны нөлөө, үнэ цэнэ нэмэгдсэн. Тиймээс ч хорио цээрийг сүсэг бишрэл, итгэл

үнэлэмжийг шашин, харин хэрэглээг шинжлэх ухаан тэтгэн, хүн төрөлхтний соёл иргэншлийн эргэлтийг дагуулж ирсэн. Шинжлэх ухаан нь нийгэм, эдийн засгийн амьдралыг эрхшээхийн хирээр судалгаа, задлан шинжилгээ, туршилтын “засаглал” оюун санааны бүх хүрээ салбарт түрэн ноёрхов. Тиймээс ч анхны сонин сэтгүүлийнхнийг “мэдээний үе” (тоочин өгүүлэх), XVII-XIX зууныг эсээ, хошин шог өгүүлэл, онигоо, зохиомол дуулианы эрин (уран сайхны) харин XX зууныг нийтлэл, задлан шинжилгээний өгүүлэл, тайлбарынх гэж болно.

**З**адлан шинжилгээний бичлэгийн онцлог нь ч үг хэл, хэтрүүлэл билэгдэл бус харин үзэл санаа, онол тайлбараар цаг үеийн үйл явдал, үзэгдлийг дүгнэн үнэлэх цаашилбал нөлөөлөх, итгэн үнэмшүүлэх зорилгод байгаа юм. Өөрөөр хэлбэл нийгмийн үнэлэмж дэг журам, итгэл үнэмшлийг хувь хүнд төлөвшүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх үүрэг зорилго задлан шинжилгээний нийтлэлд зонхилдог гэсэн үг. Тиймээс ч нийтлэлийн үр нөлөө, бичлэгийн ур чадварыг зохиогчийн мэдлэг, туршлага, үзэл баримтлал тодорхойлдог. Монголын нийтлэл зүйн онцлог болох хошин шог, ёгтлолт үг, санаа, амьдчилал, дүршүүлэл, далд утга санаа зэрэг илэрхийлэл нь ч зохиолч, яруу найрагч, эрдэмтэн судлаачид сэтгүүл зүйн хөгжлийн эхэн үеэс гол тэргүүлэгч нийтлэлчид байсантай холбоотой. Их зохиолч Д.Нацагдорж шүлэглэсэн хэлбэрээр эрүүл мэндийн тухай нийтлэл бичиж, Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, Л.Түдэв нарын эрдэмтэн зохиолчдын бий болгосон уламжлал, дэг загвар үргэлжилж, өнөөгийн нийгмийн үзэл санааны лидерүүд болох Баабар, Б.Цэнддоо, Жаргалсайхан (эдийн засагч),

Д.Баярхүү, Н.Багабанди нараар Монголын задлан шинжилгээний сэтгүүл зүйн “түүх” оршсоор байна. Гэхдээ дээрхи дүгнэлт нь монголын өнөөгийн нийтлэлчдийг бүхэлд тодорхойлно гэвэл өрөөсгөл хэрэг бөгөөд тэргүүлэх нөлөө бүхий хүрээний тухай дүгнэлт юм.

Манай нийтлэлчдийн дийлэнх нь улс төрчдийн үзэл тайлбарыг давтсан, түүнийгээ ганц нэг жишээ, баримтаар “хачирласан” эсвэл хэт өрнөдийн, монголын нийгэм, үндэстний онцлог, бодит байдлаас хэтийдсэн, бүр захиалгат “төлбөрт” бичвэрийн зохиогчид болсон. Энэ нь төрөөр тэтгүүлэх, төрд бүхнээ даатгах сэтгэлгээг хөхүүлэн дэмжсэн, хэт үгүйсгэл, гутранги үзлийг өөгшүүлсэн, хувь хүний “Би” хэмээх эрх ашгийг “магтсан” нийтлэлийн агуулгын давамгайллаар нотлогдож байна. Цаашилбал нийтлэлийн зорилго нь олон нийтийн санаа бодол, анхаарлыг татах, улс төрийн PR, эрх мэдэлтнүүдийн эрх ашиг, бодлогыг “сурталчлах”, цаг үеийн дуулиан шуугиант үйл явдлыг үндэслэн эрс үгүйсгэл, туйлшрал бүхий хандлагыг дэвэргэх “үзэгдэл”-д оршиж байгаа юм.

Гэтэл задлан шинжилгээний нийтлэлийн зорилго нь үнэнийг олох, үйл явдал, үзэгдлийн мөн чанарыг тодотгох, шинэ үзэл санаа дэвшүүлэхэд оршдог. Хүний сэтгэлгээний талаасаа ч задлан шинжлэхүйн “орчил” нь ч шинжлэх ухаан бөгөөд үнэнийг танин мэдэх, судалгаанд тулгуурлах, учир шалтгаанд үндэслэх, бүхний хүлээн зөвшөөрч буй мэдлэгт эргэлзэх гэсэн зорилго, чанараар тодорхойлдог.

Мэдээж сэтгүүл зүй нь шинжлэх ухаанаас ялгаатай, өөрийн гэсэн онцлог, үнэлэмжтэй. Сэтгүүл зүйд цаг үеийн үйл явдал үзэгдлийг тусгах, олон нийтэд сонирхолтой чухал баримт

асуудлыг сонгох, ойлгомжтой товч байх, содон, онцгой тохиолдлыг өгүүлэх, дүр, олны танил хүнээр дамжуулан үзэл санаагаа тодотгох гэсэн шалгуурыг баримталдаг. Гэхдээ судалгааг дээдлэх, үйл явдлын мөн чанарыг өнгөрсөн, ирээдүйн үзэгдэл, баримтаар шүүн тунгаах, учир шалтгаан, уялдаа холбоотой дүгнэх зэрэг “чанар”-ыг эрхэмлэх учиртай. Өдгөө интернет, ухаалаг технологи, мэдээллийн их өгөгдлийн сан гээд задлан шинжлэх баримтын асар өргөн нөөц, түүнийг боловсруулах боломж бодитой зүйл болжээ. Тиймээс ч “санаа” бүхнээс үнэтэй баялаг хэмээн хүлээн зөвшөөрөгдөж байна. Нийтлэлийн агуулгыг ч бусад баримт, үйл явдалтай хэрхэн уялдаа холбоотой байна, учир шалтгааныг тодотгов уу, үнэ цэнэ бүхий “санаа” тайлбарыг илэрхийлэв үү, шинэ үнэлэлт дүгнэлт өгөв үү, цаашилбал үзэл бодлын өрсөлдөөний орчинд нөлөө үзүүлэв үү гэсэн шалгуураар дүгнэх ёстой.

Ийнхүү баримт (өгүүлэмж, тоочимж), дүр дүрслэл (уран сайхан, хүнчлэл, билэгдэл) дүн шинжилгээ (задлан шинжилгээ) гэсэн сэтгэлгээ хандлагын “өнцөг”-ийн хүрээнд зохиогчийн бодол санаа, илэрхийллийн “хөдөлгөөн”, хам шинж оршдог болно. Нөгөө талаар баримт үнэнийг (дүн шинжилгээ, тайлбар) агуулж, үнэн баримтыг ойлгох үндэс болохын сацуу энэ бүхнийг сонирхолтой итгэл үнэмшилтэй өгүүлэхэд дүр дүрслэл (уран сайхан) нөлөөлдөг гэсэн дүгнэлтийг нэмж болно. Орчин үеийн нийтлэлд ч “нэг санаа, хоёр нотолгоо, гурван хуудас” гэсэн бичлэгийн хуучны мөрдлөг хэвээр хүчинтэйн дээр тоо (баримт), дүр (төлөөлүүлэл, билэгдэл), үр дүн (дүгнэлт тайлбар) гэсэн шалгуур үзүүлэлт ч үр нөлөө, үнэ цэнийг тодорхойлж байгааг хэлэх хэрэгтэй.



Энэ бүхнээс дүгнэхэд Монголын өнөөгийн нийтлэлийн онцлог нь “зохиогч төвт” буюу нийгмийн эрх ашиг, үнэлэмжийн гэхээсээ илүү бие хүний үзэл бодол, байр суурийн илэрхийллийнх байгаад оршино. Мөн задлан шинжилгээ, судалгаа бус харин ёгтлол, хэтрүүлэл, амьдчиллаар утга санаагаа тодотгож буй нь ч нийтлэлчийн байр суурь зонхилж байгааг илтгэнэ. Энэхүү зохиогчийн хүчтэй нөлөө нь ч хэтийдсэн, зөрчилт, “захиалгат” агуулга бүхий өнөөгийн нийтлэлийн “түрэлт”-ийн гол шалтгаан болж байна. Тиймээс нийгмийн эрх ашиг, нэгдмэл, зонхилогч үнэлэмжийг бататгасан, судалгаа тоо, баримтыг задлан шинжилсэн, мэргэжлийн сэтгүүл зүйн хэм хэмжээний түвшинд нийцэхүйц нийтлэл үгүйлэгдсээр байна.

### **Ишлэл**

- <sup>1</sup> Грабильников А. А. 2001. Работа журналиста в прессе. М., с. 72.
- <sup>2</sup> Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ., 257-258 дахь тал

### **Ашигласан бүтээлийн жагсаалт**

1. Грабильников А. А. Работа журналиста в прессе. М. 2001.
2. Зулькафиль М. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ. 2005.

### **Summary**

This article concludes that the current feature of Mongolian publications is “author-oriented” content with a predominantly artistic approach. Thus, the comment was made in the context of the conceptual “corner” of the conceptualization of literature as a relationship between a person and society, the evolution of information thinking, value thinking, and quantitatively figurative-analytical analysis.